

БАТЛАВ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА И.БАТТӨГС

2024 оны 01 дүгээр сарын 14 өдөр

2.0 КМ АВТО ЗАМЫН АЖИЛ (УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 20
ДУГААР ХОРОО)-ЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2024 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

1.	Ажлын зорилго үндэслэл	<ul style="list-style-type: none">- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;- Монгол Улсын Их хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг;- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;- Баянзүрх дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;- “Баянзүрх дүүргийн хөгжлийн зураглал-2030” дунд хугацааны бодлогын баримт бичиг;- Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 15 дугаар хуралдааны 80 дугаар тогтоол;
2.	Байршил, Зориулалт хүчин чадал	<ul style="list-style-type: none">- Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Арцатын амны хэсэгт 2.0 км авто замын ажил;
3.	Архитектур төлөвлөлтийн объектын бүрэлдэхүүн шаардлага, зориулалт, хүчин чадал	<ul style="list-style-type: none">- Авто зам: 3.5 метрээс багагүй өргөнтэй 2 эгнээ байх (7.0 метрээс багагүй байх);- Явган хүний зам: Өргөн 1.5 метрээс багагүй байх;- Дугуйн зам: Өргөн 2.0 метрээс багагүй байх;- Гэрэлтүүлэг: 30 метр тутамд 9-12 метрийн өндөртэй шон, 150 Вт чадалтай чийдэн байх;- Тэмдэг тэмдэглэгээ: Явган болон автомашинаар зорчигчдын аюулгүй байдлыг хангасан тэмдэг тэмдэглэгээ хийгдсэн байх;
4.	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	<ul style="list-style-type: none">- Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт;

5.	Авто замын техникийн ангилал, замын зэрэг	- Нийслэлийн авто зам, Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам;
6.	Замын хучилтын хийц	- Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэх; - Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын техникийн нөхцөлийг хангаж автомашин, явган хүний хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх боломжийг хангах зорилгоор барих;
7.	Зураг төслийн иж бүрдэл	- Инженер геодезийн ажлын тайлан; - Инженер геологийн судалгааны ажлын тайлан; - Авто зам, замын байгууламжийн ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөл; - Тайлбар бичиг (хучилтын тооцоо, ус зүйн тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, авто зам, замын байгууламжийн зураг төслийн бүрдэл, холбогдох захирамж, техникийн нөхцөл, магадлалын дүгнэлт гэх мэт); - Техникийн шаардлага; - Холбогдох шугам сүлжээний зураг төсөл, төсөв; - Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв; - Төслийн танилцуулга;
8.	Эдийн засгийн тооцоо төсөв.	- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдсөн бусад программаар тооцох;
9.	Тавигдах шаардлага	- Гүйцэтгэгчээр шалгарсан компани нь ажил эхлэхийн өмнө Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газартай зөвшилцөх ба Хот байгуулалт, Хөгжлийн газар болон Нийслэлийн замын хөгжлийн газрын даалгавруудын шаардлагуудыг хангаж ажиллах;
10.	Онцгой нөхцөл	- Газар чөлөөлөлт, дэд бүтцийн шугам сүлжээ шилжүүлэх, ажлуудаас үүдэж алдагдах хугацааны асуудлыг захиалагч байгууллага хариуцахгүй болохыг анхаарах;

ХЯНАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ДАВААСАМБУУ

БОЛОВСРУУЛСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.БАТБАЯР

ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АВТО ЗАМЫН ХАВСРАЛТ



ТАНИХ ТЭМДЭГ

Төлөвлөж буй авто зам